

ФИЛОСОФИЙН ТҮҮХ СУДЛАЛД

Г.ЭРДЭНЭБАЯР

МУИС, НШУС, Философийн тэнхим

Түлхүүр үг: Философи, Философийн түүх, Онол, Арга зүй.

Философийн түүх нь философийн мэдлэг ухаан хөгжиж ирсэн түүх билээ. И.Кантын хэлснээр,"Аливаа философич өмнөх үеийн балгас дээр өөрийн орд харшаа бүтээж иржээ". / И.Кант.Логика – Трактаты и письма.М.,1980.с.332./ Ийнхүү философид шинэ шинэ үзэл бий болдог ч, өмнөх үеийн үзэл сургаалиудаас нэг нь ч ор мөргүй алга болдоггүй. Учир нь философийн судлах зүйл өргөн хүрээтэй, олон талтай бөгөөд философичид өөр өөрийн онол, сургаалийг боловсруулдаг. Философийн түүхэн дэх чиглэл бүхэнд үнэний тодорхой хувь бий. Тэдгээр чиглэлүүд нь ертөнцийг өөр өөрийн үзлийн үүднээс судална. Мөн философи дах чиглэлүүд нь харилцан бие биенээ шүүмжлэн няцааж, бас нөхөн гүйцээж, нэг нь нөгөөгөө хөгжүүлж байдаг юм.

Философийн түүхийг сайтар системтэй судлахгүйгээр философийг ойлгох боломжгүй. Философи шиг түүх нь онцгой үүрэг гүйцэтгэдэг мэдлэгийн салбар байхгүй гэж хэлж болно. Философийн түүхэнд үзэл сургаал нь түүх биш, өнөө үед ч орчин үеийнх шиг чухал байдаг үзэл сургаал олон буй. Тухайлбал, Платон, Аристотель, Кант, Гегель, Ганди гэх мэт олон үзэл баримтлал бий.

Өнөөгийн манай нийгэмд философийн түүхийн үүрэг, ач холбогдлыг үл ойшоох хандлага зарим талаар ажиглагддаг. Ийм байж таараахгүй. Яагаад гэвэл философийн түүхийг судлах нь аливаа асуудлыг олон хувилбараар сэтгэж, ургуулан бодож, шүүн тунгааж, илүү оновчтой шийдвэр гаргах, хүн буй хүн философийн бүх системийг гагцхүү оюун ухааныг хэрэглэсний түүх гэж, бас философийн авьяас билгээ дасгалжуулах объект гэж үзэх ёстой. Ийм талаар Германы философич И.Кант хэлэхдээ: " Философидож сурхыг хүсэж түүхэнхүү философич бие даасан сэтгэгчийн хувьд оюун ухаанаа боолын учраас үнэнхүү философич бие даасан сэтгэгчийн хувьд оюун ухаанаа боолын

ёсоор дуурайх биш, чөлөөтэй бөгөөд өвөрмөц содон хэрэглэх ёстой"/ И.Кант.
Логика – Трактаты и письма. М., 1980. с.334./ гэжээ.

Мөн түүнчлэн философиин түүхийг судлах нь өмнөх үеийн философичид ямар асуудлыг хэрхэн судалж, ямар аргаар шийдвэрлэсэн, тэдгээрээс юуг нь орхих, юуг нь уламжлан авах шаардлагатайг мэдэж, улмаар цаашид хийх судалгааны чиг баримжааг тогтооход ч ач тустай юм. Нөгөө талаар даяаршлын өнөө үед хүн төрөлхтөн нийтлэг эрх ашгаа ухаарч, олон улсын харилцаа ихээхэн өргөжиж, харилцан бие биенийхээ хэл, түүх, соёлоос суралцах шаардлага ч зүй ёсоор нэмэгдэж байна. Үүнтэй уялдаж бид хүн төрөлхтний философиин баялаг өв уламжлалаас судалж эзэмших нь дэлхийн соёлтой харилцан нэвтрэлцэх, хөгжих нэг арга зам мөн.

Ийм ч учраас орчин үеийн философиийн урсгал чиглэлүүдэд урьд үеийн соёлын өв санг судлах, түүний дотор урьд үеийн философичдын эх зохиол бүтээлийг судлах талаар ихээхэн ажлыг хийж байгаа болно. Өrnөдийн орнуудад өмнөх үеийн бараг бүх сэтгэгчдийн зохиол бүтээлийг орчуулан хэвлэжээ. Олон зохиол бүтээлийг харьцуулах болон эх бичгийг судлах, өмнө үеийн томоохон сэтгэгчдийн талаар нэг бүрчилсэн судалгаа явуулж байна. Үүний үр дүнд философиин түүх судлалд томоохон амжилт олсон билээ.

Философиин түүхийг судлан авч үзэх онол арга зүйн үндэслэл, баримжааллын хувьд орчин үеийн философиийн урсгал чиглэлүүд хийгээд өмнөх үеийн философиийн түүх судлал зарим талаараа ялгаатай байна. Эдүгээх философиийн урсгал чиглэлүүдэд идеалист арга зүй нэлээд тод томруун харагдаж байна. Нийгэм, түүний дотор философиийн түүхийн эцсийн шалтгаан нь нийгэм, нийгмийн ахуйтай холбоотой хэмээн Марксизм үздэг. Гэтэл орчин үеийн олонхи чиглэлд энэ үзлийг зөвшөөрдөггүй. Философи сэтгэлгээний хөгжлийн уг сурвалжыг оюун санаа ухамсраас, философиос өөрөөс нь гаргаж тайлбарлах хандлага давамгайлж байна. Тухайлбал, Б.Рассел "Өrnө дахины философиийн түүх" зохиолдоо: Философиийн сэтгэлгээг тэр үеийнх нь олон нийтийн санаа бодлоос төрж гардаг гэсэн арга зүйг баримталсан нь буй. Олон нийтийн санаа бодол, философи сэтгэлгээнд зүй ёсоор нөлөөлдөг тал бий.

Тэрээр олон нийтийн санаа бодлоос философи төрж гардаг. Эргээд философиос олон нийтийн санаа бодол гарч байдаг гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг.

Марсель Геру (1891-1978), Буйе (1857-1961) зэрэг философийн түүх судлаачид үзэхдээ: “Философиин түүх гэдэг бол өөр хоорондоо ямар нэг холбоогүй, философиин урсгал чиглэлүүдийн цуглуулга мөн гэж үзсэн байдаг. Хичнээн философич байвал төчнөөн философи байна гэж үздэг. Энэ бол хэрэг дээрээ уг философиин сургаалаас гарч буй дүгнэлт юм.”

Эдүгээ буй философиин чиглэлүүд өөрийнхөө үзэл болгож буй тэр үзэл санаагаа нийт хүн төрөлхтний шинжтэй болгох эрмэлзэл тод ажиглагддаг. Орчин үеийн философиин урсгал чиглэлүүдэд космополитизмын үзэл санаа нэлээд дэлгэрсэн нь ажиглагддаг. Ялангуяа өرنэ төвлөг үзэл, дорно төвлөг үзэл нэгэн үе ихэд дэлгэрч байв. Угтаа өرنэ ба дорно дахины ард түмнүүдийн соёл хоорондоо ялгаатай, өөр өөрийн онцлогтой байдаг. Энэ талаар өرنэ дахины философи бол ихэвчлэн гадаад ертөнцийн танъж мэдэхэд чиглэсэн, харин дорно дахины философи бол хүний дотоод ертөнц рүү илүү хандсан чиг хандлагатай хэмээн үзэх үзэл дэлгэрсэн байна. Өрнө дахины философиid ертөнцийг танин мэдэх арга болгон сэтгэхүй-рационализмыг үндэс болгодог бол дорно дахинд бясалгал, зөн билгийг танин мэдэхүйн гол үндэс болгон тавьдаг онцлог бий. Дорно дахины философи нь ихэвчлэн шашны далдыг үзэх үзэлд үндэслэдэг гэх мэтээр өрнө, дорны сэтгэлгээг сөргүүлэн тавьдаг тал ажиглагддаг. Өрнө төвлөг үзэлд: дорно дахины философи гэдэг бол угтаа сэтгэлгээний ямарваа нэгэн боловсруулалт үгүй, ёс суртахууны сургаалаар хязгаарлагдаж байгаа учраас философиин түүхийг зөвхөн Грекийн философиос эхлэх ёстой хэмээн үзэх нь буй. Дорно төвлөг үзэл нь үүний философиос эхлэх ёстой хэмээн үзэх нь бий. Дорно төвлөг үзэл нь тодорхой цаг үед үгүйсгэж болохгүй. Өрнө, дорнын философиин аль аль нь тодорхой цаг үед тухайн ард түмний оюуны соёлын охь шим болон үүсэн бүрэлдэж, өөрийн

Арга зүйн үүднээс дорно, өрнийн философиин өвөрмөц онцлогыг үгүйсгэж болохгүй. Өрнө, дорнын философиин аль аль нь тодорхой цаг үед тухайн ард түмний оюуны соёлын охь шим болон үүсэн бүрэлдэж, өөрийн

өвөрмөц онцлогтой байж, тодорхой асуудлуудыг өөрсдийн арга, арга зүйн хурээнд дэвшүүлэн тавьж, тайлбарлаж ирсэн билээ.

Хүрээнд дэвшүүлж тавиж, чадахаас зуу дахин бодитой. Асуудлыг Энэ талаар "Буддизм христийн шашнаас зуу дахин бодитой. Асуудлыг бодитойгоор уужуу авч үзэх хандлага түүнд угаас шингэмэл бөгөөд тэрээр хэдэн зуун дамнан үргэлжилсэн философи эргэцүүллийн үр дүнд үүссэн... Буддизм бол түүхэн дэх цор ганц жинхэнэ эерэг шашин, энэ нь танин мэдэхүйн онолд нь ч хамаатай. Бодит байдлын үнэнийг бүрмөсөн хүлээн зөвшөөрч, "нүгэлтэй" тэмцэхийг биш, "зовлонтой" тэмцэхийг номложжээ" хэмээн Ф. Ницше " Христ шүтлэгтний эсрэг" зохиолдоо Христосын болон Буддын соёлын үндсэн баримтлал тэс өөр хэмээн үзэж, буддизмыг илүү өндөр үнэлсэн буй./ Антихрист.- Ф. Ницше. Соч.т.2.М.,1990./

Орчин үед ч философиийн олон урсгал чиглэлүүд зэрэгцэноршиж байна. Тэдгээрт бүх нийтээр хулээн зөвшөөрдөг, дэлхийн хэмжээний нэгдмэл философиийн систем гэж үгүй гэдгийг мартаж болохгүй юм. Харин философиийн урсгал чиглэл бүрт өөрийн арга зарчим, өөрийн үнэн буй гэдгийг хулээн зөвшөөрөх ёстой билээ.

Үргэлжлэл бий